ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр Дугаар 461 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэрийн нийт 31,639,178.00 (гучин нэгэн сая зургаан зуун гучин есөн мянга нэг зуун далан найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн удирдах зөвлөлийн дарга Ч.Ренчиндамба, ерөнхий инженер бөгөөд гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

D:\Huraldaanii material\2020 on\2020.09.22 14r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 09
дүгээр сарын 22-ний өдрийн 461
дугаар тогтоолын хавсралт

"Баянчандмань-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Асфальто зүсэгч хөрөө /Хятад/	2014	ш	1	3,900,000.00	3,900,000.00
2	Богино долгионы радио станц	2002	ш	1	8,970,800.00	8,970,800.00
3	Зөөврийн ШТС	2002	ш	1	13,673,700.00	13,673,700.00
4	Токарийн суурь машин /1к-62/	1992	ш	1	1,442,400.00	1,442,400.00
5	Өрмийн машин	1990	ш	1	2,720,900.00	2,720,900.00
6	Бичгийн хүрэн ширээ	2012	ш	1	175,000.00	175,000.00
7	500-ын жин	1978	ш	1	206,200.00	206,200.00
8	Багажны модон хөл PFW1	2003	ш	1	412,500.00	412,500.00
9	Рейк багаж SUM 43	2003	ш	1	90,700.00	90,700.00
10	Хувцас хатаагч з.үүр	2015	ш	1	46,978.00	46,978.00
				10		31,639,178.00
	Нийт дүн			10 (арав)		31,639,178.00 (гучин нэгэн сая зургаан зуун гучин есөн мянга нэг зуун далан найман)